



УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН ТУШААЛ

2024 оны 09 сарын 02 өдөр

Дугаар 4/144

Улаанбаатар хот

Шарилж устгалын ажил зохион байгуулах тухай

Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.3.1, 24.3.3 дахь заалт, 24.6 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2, 16.5.5 дахь заалт, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны дүрмийн 2 дугаар зүйлийн 2.2 дахь хэсэг, 3 дугаар зүйлийн 3.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хөл газрын ургамлын харшлаас урьдчилан сэргийлэх, нийтийн эзэмшлийн гудамж талбайн шарилж, зэрлэг ургамлыг хадаж, цэвэрлэн иргэдийн эрүүл цэвэр орчинд ажиллаж, амьдрах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор хөл газрын ургамал устгалын аяныг 2024 оны 08 дугаар сарын 28-ны өдрөөс 09 дүгээр сарын 10-ны өдрийн хооронд зохион байгуулсугай.

2. Шарилж устгалын ажилд шаардагдах зардлын тооцоог хавсралтаар баталсугай.

3. Дээрх ажлын хүрээнд аж ахуйн нэгж, байгууллага, айл өрхийн гадна орчны 50 метр хүртэлх зам талбайн шарилж, зэрлэг ургамлыг хариуцсан байгууллага, иргэдээр хадуулж цэвэрлүүлэх, хариуцах эзэнгүй нийтийн эзэмшлийн гудамж талбайн шарилж, зэрлэг ургамлыг хадаж цэвэрлэх ажлыг мэргэжлийн байгууллагатай гэрээ байгуулан гүйцэтгүүлэх, үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар ханган, хяналт тавьж, сурталчилж ажиллахыг Орчны бохирдол, хог хаягдлын удирдлагын хэлтэс (Б.Мөнх-Эрдэнэ)-т үүрэг болгосугай.

4. Хөл газрын ургамал устгалын ажилд шаардагдах 191,800,000 (Нэг зуун ерэн нэгэн сая найман зуун мянга) төгрөгийг "Шарилжгүй-Улаанбаатар аяныг зохион байгуулах зардлаас санхүүжүүлэхийг Ахлах нягтлан бодогч (Б.Халиун)-д зөвшөөрсүгэй.

5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, санхүүгийн удирдлагын газар (Н.Отгонбаяр)-т даалгасугай.

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР
БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ
ДАРГА Ц.ТӨРХҮҮ

Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн
~~2004~~ оны ~~09~~ дүгээр сарын ~~02~~-ны өдрийн
~~АИЧУ~~..... тушаалын хавсралт

ШАРИЛЖ УСТГАЛЫН АЖИЛД ШААРДЛАГАТАЙ ЗАРДЛЫН ТООЦОО

№	Зардлын нэр	хэмжих нэгж	нэгж үнэ (төг)	тоо хэмжээ (м2)	нийт зардал
1	2	3	4	5	6
1	Сонгинохайрхан дүүргийн нутаг дэвсгэрийн хариуцах эзэнгүй нийтийн эзэмшлийн гудамж талбайд ургасан шарилж, зэрлэг ургамлыг хадаж цэвэрлүүлэх ажлын зардал	мкв	70	283,000	19,810,000
2	Чингэлтэй, Сүхбаатар дүүргийн нутаг дэвсгэрийн хариуцах эзэнгүй нийтийн эзэмшлийн гудамж талбайд ургасан шарилж, зэрлэг ургамлыг хадаж цэвэрлүүлэх ажлын зардал	мкв	70	283,000	19,810,000
3	Хан-Уул дүүргийн нутаг дэвсгэрийн хариуцах эзэнгүй нийтийн эзэмшлийн гудамж талбайд ургасан шарилж, зэрлэг ургамлыг хадаж цэвэрлүүлэх ажлын зардал	мкв	70	283,000	19,810,000
4	Баянгол дүүргийн нутаг дэвсгэрийн хариуцах эзэнгүй нийтийн эзэмшлийн гудамж талбайд ургасан шарилж, зэрлэг ургамлыг хадаж цэвэрлүүлэх ажлын зардал	мкв	70	283,000	19,810,000
5	Баянзүрх дүүргийн нутаг дэвсгэрийн хариуцах эзэнгүй нийтийн эзэмшлийн гудамж талбайд ургасан шарилж, зэрлэг ургамлыг хадаж цэвэрлүүлэх ажлын зардал	мкв	70	283,000	19,810,000
6	Сонгинохайрхан дүүргийн нутаг дэвсгэрийн хариуцах эзэнгүй нийтийн эзэмшлийн гудамж талбайд ургасан шарилж, зэрлэг ургамлыг хадаж цэвэрлүүлэх ажлын зардал	мкв	70	265,000	18,550,000
7	Чингэлтэй, Сүхбаатар дүүргийн нутаг дэвсгэрийн хариуцах эзэнгүй нийтийн эзэмшлийн гудамж талбайд ургасан шарилж, зэрлэг ургамлыг хадаж цэвэрлүүлэх ажлын зардал	мкв	70	265,000	18,550,000
8	Хан-Уул дүүргийн нутаг дэвсгэрийн хариуцах эзэнгүй нийтийн эзэмшлийн гудамж талбайд ургасан шарилж, зэрлэг ургамлыг хадаж цэвэрлүүлэх ажлын зардал	мкв	70	265,000	18,550,000
9	Баянгол дүүргийн нутаг дэвсгэрийн хариуцах эзэнгүй нийтийн эзэмшлийн гудамж талбайд ургасан шарилж, зэрлэг ургамлыг хадаж цэвэрлүүлэх ажлын зардал	мкв	70	265,000	18,550,000

1	2	3	4	5	6
10	Баянзүрх дүүргийн нутаг дэвсгэрийн хариуцах эзэнгүй нийтийн эзэмшлийн гудамж талбайд ургасан шарилж, зэрлэг ургамлыг хадаж цэвэрлүүлэх ажлын зардал	мкв	70	265,000	18,550,000
	Нийт			2,740,000	191,800,000